

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Гүйцэтгэлийн удирдлагын баримт бичиг

**БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА**

Байгууллагын нэр: **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНХУЯГ

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Н.БОЛОРМАА

2022 он

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНГИЙН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр

Нэг. Хяналт- шинжилгээ, үнэлгээний зорилго:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд/-аас төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилт, арга хэмжээний гүйцэтгэл тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Арга зүй, ашигласан эх сурвалж:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2022 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар нэгтгэсэн явцын тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, зорилтууд, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинтэй харьцуулан дүгнэв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

Төсвийн ерөнхийлөн захирагч /Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд/-аас Төсвийн шууд захирагч /Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга/-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд 2022 оны 12 дугаар сарын 12-ны байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээг хийлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 10 зорилтын 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилт, 13 арга хэмжээ;
- Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 1 зорилт, 22 арга хэмжээ;
- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 4 зорилт, 17 арга хэмжээ;
- Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилт, 15 арга хэмжээ байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг газар тус бүрээр харуулбал:

№	Газар, хэлтэс	Арга хэмжээний тоо	Арга хэмжээний дугаар
---	---------------	--------------------	-----------------------

1	Бодлогын хэрэгжилт, судалгааны газар	19	1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.9, 1.10, 1.11, 1.12, 1.13, 2.16, 2.17, 2.18, 2.20, 2.21, 2.22, 3.15.
2	Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Сургалт олон нийт хамтын ажиллагааны газар	1	1.8.
3	Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Сургалт олон нийт хамтын ажиллагааны газар, Санхүү бүртгэлийн газар	1	3.14.
4	Дотоод аудит, мониторингийн газар	5	3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5
5	Мэдээллийн технологийн төв	7	2.19, 4.10, 4.11, 4.12, 4.13, 4.14, 4.15.
6	Санхүү бүртгэлийн газар	15	2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9, 2.10, 2.11, 2.12, 2.13, 2.14, 2.15.
7	Сургалт олон нийт хамтын ажиллагааны газар	6	3.16, 3.17, 4.3, 4.4, 4.5, 4.6.
8	Тамгын газар	7	3.9, 3.10, 4.1, 4.2, 3.11, 3.12, 3.13.
9	Хяналт шалгалтын газар	3	3.6, 3.7, 3.8.
10	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс	3	4.7, 4.8, 4.9.
Нийт		67	

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг харуулбал:

- “Үр дүнтэй” буюу зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, 100 хувийн хэрэгжилттэй 48 арга хэмжээ;
- “Тодорхой үр дүнд хүрсэн”:
 - Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох шийдвэр гарсан, үр дүн гарч эхэлсэн 90 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ;
 - Тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гүйцэтгэл нь 70 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ;
- Хэрэгжих хугацаа болоогүй 1 арга хэмжээ: Монгол Улсыг (2021-2025) хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; /*Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.5 дах арга хэмжээ*/;

Тус хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг зорилт, арга хэмжээгээр харуулбал:

- **Бодлогын баримт бичигт тусгагдсан 1 зорилтын 13 арга хэмжээ:**

1. “Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт **98,5** хувь;

➤ **Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн 1 зорилтын 22 арга хэмжээ:**

1. “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт **92,3** хувь;

➤ **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийн 4 зорилтын 17 арга хэмжээ:**

1. “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 100 хувь;

-Хугацаа болоогүй 1 арга хэмжээ;

2. “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 90 хувь;

3. “Төрийн захиргаа, хүний нөөц” арга хэмжээний биелэлт 98,0 хувь;

4. “Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” арга хэмжээний биелэлт 100 хувь;

➤ **Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 4 зорилтын 15 арга хэмжээ:**

1. “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 85,0 хувь;

2. *“Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 97,5 хувь;

3. *“Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх”* гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 100 хувь;

4. *“Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх”* гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 88,3 хувь;

Цаашид холбогдох газруудтай хамтран биелэлт, үр дүнг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх шаардлагатай 70 хувийн гүйцэтгэлтэй 8 арга хэмжээ байна.

- Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, хуримтлалын сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулж, нэмэгдүүлэх ажил зохион байгуулах;
/ГТ-ний 2.9 дэх арга хэмжээ/
- “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Нийгмийн даатгалын салбарын нягтлан бодох бүртгэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх;
/ГТ-ний 2.15 дах арга хэмжээ/
- НД-7, НД-8 тайланг ажил олгогчоос тоон гарын үсгээр хүлээн авах ажлыг эрчимжүүлэх;
/ГТ-ний 2.19 дэх арга хэмжээ/
- Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар баталсан нийгмийн даатгалын салбарын статистикийн мэдээллийн маягтыг Үндэсний статистикийн хороотой хамтран шинэчлэн боловсруулах;
/ГТ-ний 2.22 дах арга хэмжээ/
- Нийгмийн даатгалын тухай хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, батлагдсан удирдамжийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажил үйлчилгээний үр дүнг тооцож ажиллах;
/ГТ-ний 3.6 дах арга хэмжээ/
- ISO 9001:2015 олон улсын стандартад нийцсэн чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;
/ГТ-ний 4.1 дэх арга хэмжээ/
- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд мэдээллийн шинэчилсэн системийг турших, нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлэх;
/ГТ-ний 4.11 дэх арга хэмжээ/
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтоолгох өргөдөл, материалыг даатгуулагчаас цахимаар хүлээн авч, шийдвэрлэх ажлыг эхлүүлэх;
/ГТ-ний 4.14 дэх арга хэмжээ/

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг **94,8** хувиар дүгнэж **“Тодорхой үр дүнд хүрсэн”** гэж дүгнэсэн.

2. Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой дээд газраас гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт харьцангуй шуурхай, тогтмол хийгдсэн байгаа нь ажлын явц, үр дүнгээс харагдаж байна.

3. Холбогдох нэгжүүд зорилт арга хэмжээний хэрэгжилтийн явцыг тайлагнахдаа тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлыг товч бөгөөд тодорхой бичиж, зорилтот түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгааныг бичиж хэвших;

4. 2023 оны төлөвлөгөөг боловсруулах талаар дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр бий болох үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгах;
- Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь тухайн жилдээ хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэх, хэмжигдэхүйц, үр дүнг харуулсан байх;
- Зорилтот түвшин нь бодлогын баримт бичиг, статистик тоон мэдээлэл, зорилтын үр дүнг илэрхийлсэн байх;

Нийгмийн даатгалын ерөнхий газрын төсвийн шууд захирагчийн 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг хавсаргав.

ДОТООД АУДИТ, МОНИТОРИНГИЙН ГАЗАР

Хянасан:
ДАМГ-ын дарга

Б.Ганхуяг

Боловсруулсан:
Мэргэжилтэн

Н.Болормаа